

## Монгол судлалын эрхэм нөхөр - Ю.Кузьмин

**Оохнойн Батсайхан**<sup>ID\*</sup>

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

[batsaikhano@mas.ac.mn](mailto:batsaikhano@mas.ac.mn)

**Цэдэндамбын Батбаяр**<sup>ID</sup>

Академич, доктор (Sc.D)

ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

[tsedendamba.bud@gmail.com](mailto:tsedendamba.bud@gmail.com)

**Авирмэдийн Даваасүрэн**<sup>ID</sup>

Доктор (Sc.D), профессор

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,

Улаанбаатар, Монгол Улс

[davaasurena@mas.ac.mn](mailto:davaasurena@mas.ac.mn)

Нэрт монголч эрдэмтний 70 насны ойд зориулав.

ОХУ-ын нэрт монголч эрдэмтэн, доктор, профессор Юрий Васильевич Кузьмин 1954 оны 3 дугаар сарын 7-нд Буриад Монголын БНАвтономит улсын Кабанскийн районд ажилчны гэр бүлд төржээ. Тэр бээр Эрхүүгийн улсын их сургуулийн түүхийн ангийг дорно дахины түүхч мэргэжлээр 1975-1981 онд дүүргэжээ.

1976 онд анх монголын түүх, археологи, угсаатны зүйн дадлагын ажлаар Монголд хөл тавьж, тухайн үед Н.Сэр-Оджав, Д.Цэвээндорж, академич Ш.Бира, Б.Ширэндэв, Ш.Нацагдорж нартай танилцаж үнэтэй сургамжийг авч байсан гаднын цөөн эрдэмтдийн нэг юм.

Тэр цагаас хойш өөрийн бүтээлч амьдралаа Орос, Монгол, дэлхийн монгол судлалын түүхэнд зориулж яваа эдүгээ 70 нас шүргэж буй нэрт монголч эрдэмтэн Кузьмин Юрий Васильевич бол монголчуудын сайн нөхөр, анд билээ.

1961-1980 оны үеийн Монголын түүхийн асуудлаар дэд эрдэмтний диссертац бичиж, 1986

онд Ленинградын их сургуулийн Дорно дахины факультетад хамгаалсан байна. Түүний эрдэм шинжилгээний удирдагч нь нэрт хятад судлаач, түүх судлаач Лев Абрамович Березный, шүүмжлэгчид нь Оросын нэрт дорно дахин судлаач Е.И.Кычанов, М.И.Гольман нар байв.

Эдүгээ түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ю.В.Кузьмин нь Монголын түүх, Монгол Оросын харилцааны асуудлаар 20 гаруй нэг сэдэвт бүтээл, 500 эрдэм шинжилгээний нийтлэл бичсэн Оросын алдартай монгол судлаач болжээ. ОХУ-ын Эрхүүгийн Байгалийн их сургуулийн гавьяат профессор Ю.В.Кузьминий эрдэм шинжилгээний бүтээлүүд Монгол, Франц, Польш, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Герман, АНУ-д хэвлэгдсэн байна.

Тэр бээр олон жилийн судалгааныхаа үр дүнд “Оросын нийгэм, улс төрийн сэтгэлгээн дэх Монгол, Урианхайн асуудлууд (XIX зууны сүүл үеэс XX зууны 30-аад он)” сэдвээр түүхийн шинжлэх ухааны докторын диссертац бичиж,

\* Corresponding author

© The Author(s), 2024

<https://orcid.org/0000-0002-5543-5664>

<https://orcid.org/0000-0002-1677-5789>

<https://orcid.org/0000-0001-7259-9540>



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 22 August, 2024; Accepted: 8 November, 2024

1998 онд Эрхүүгийн их сургуулийн дэргэдэх эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлд амжилттай хамгаалсан юм. Эрдэм шинжилгээний зөвлөх нь түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Г.Н.Новиков, албан ёсны шүүмжлэгчид нь түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Т.Д.Скрынникова, Ю.М.Бутин, В.В.Грайворонский нар байсан бөгөөд түүний диссертаци өндөр үнэлгээ авсан юм.

Ю.В.Кузьмин ОХУ-ын Эрхүү, Москва, Санкт-Петербург зэрэг хотуудад буй томоохон архив, номын сангууд болон Монгол Улсын архив, номын санд Монголын түүх, монгол судлалын талаар уйгагүй эрэл хайгуул хийж, судалгаа хийсний үр дүнд “Орос-Монгол-Хятадын харилцааны систем дэх Урианхай” (Эрхүү, 2000); “П.А. Бадмаев: дипломатч, улс төрч, бизнесмен” (Эрхүү, 2002); “Сибирийн монгол судлалын түүх” (Эрхүү, 2002); “Эрхүүгийн монгол судлал: 1725–2004” (Эрхүү, 2004); “Монголын эдийн засаг ба соёл” (Эрхүү, 2004); “П.А.Бадмаевын дорно дахины төслүүд” (Эрхүү, 2006); “Профессор Н.Н.Козьмин: түүхч, эдийн засагч” (Эрхүү, 2006); “XX зууны эхэн үеийн Монгол, Хятад Оросын цэргийн судлаачдын үнэлснээр” (Эрхүү, 2007); “XX зууны эхэн үеийн Монгол, Хятад Оросын цэргийн тагнуулын үнэлснээр “Улаанбаатар, 2007); “Эрхүүд Монголыг судалсан түүх”(Эрхүү, 2011); “Эрхүүгийн монгол судлалын дэг сургууль” (Эрхүү, 2014); “Доктор П.А.Бадмаев: эрдэмтэн, дипломатч, бизнесмен”(М., 2014); «XX зууны эхэн үеийн Монгол ба Орос-Монголын харилцаа. Түүх болон түүх судлалын асуудлууд” (Эрхүү, 2016); “XX зууны Монгол болон түүний олон улсын харилцааны түүх Монгол, Оросын судлаачдын бүтээлд”(Эрхүү, 2018) зэрэг бүтээлүүдээ бичиж, нийтлүүлсэн байна.

Кузьмин Ю.В. Оросын болон Монголын түүхэнд холбогдох нэр хүндтэй алдарт хүмүүсийн намтар судлалаар олон бүтээл туурвисны дотор төвөдийн анагаах ухааны эмч Петр Александрович Бадмаевын нэр хүнд, намтрын балархай хуудсуудыг сэргээн, “П.А.Бадмаев докторын нууц” (Эрхүү, 2003), “П.А.Бадмаевын дорнын төслүүд” (Эрхүү, 2006), «Доктор П.А.Бадмаев: эрдэмтэн,

дипломатч, бизнесмен» (М., 2014) зохиолууд нь орно. Оросын эзэн хааны дэргэд шадарласан монгол гаралтай доктор Бадмаевын намтар олон буриад болон монголчуудыг сонирхлыг гойд татаж, өндөр үнэлгээ авсан билээ.

Ю.В.Кузьмин судлаачийн хувьд асуудал дэвшүүлсэн нэг сэдэвт бүтээл, түүхэн зүтгэлтний намтар (П.А.Бадмаев), эрдэмтний түүхэн намтар (Н.Н.Козьмин), баримтын эмхэтгэл (Я.П.Шишмарев), захиа захидлын өвийн нийтлэл (Б.Ринчен) гэсэн түүхийн төрөл бүрийн чиглэлээр мэргэшсэн нэгэн билээ.

Олон жилийн уламжлалтай Эрхүүгийн монгол судлалын шан татсан нэрт эрдэмтэд болох А.В.Игумнов, Я.П.Шишмарев, Н.Н.Козьмин, Н.П.Шастина, Е.М.Даревская, В.В.Свинин нарын үйл хэргийг өвлөн өвч, Монгол судлалын Эрхүүгийн дэг сургуулийг нэр төртэй үргэлжлүүлж буй эрдэмтэн бол Юрий Кузьмин юм. Өөрийн багш Владимир Вячеславович Свининий хамтаар “Эрхүүгийн монгол судлал 1725-2004: судлаачид ба бүтээлүүд” (Эрхүү, 2004), “Эрхүүд Монголыг судалсан түүх” (Эрхүү, 2011), “Монгол судлалын Эрхүүгийн дэг сургууль” (Эрхүү, 2014) гэсэн бүтээлүүдээ туурвиж, Монгол судлалын Эрхүүгийн дэг сургуулийн үүсэл, хөгжлийн түүхийг 1725 онд Эрхүү хотноо нээгдсэн Орос-монголын сургуулиас эхлүүлэн бичжээ. Сибирь бол Оросын алслагдсан хязгаар нутаг, Монголтой газар нутаг, хил хязгаарын хувьд ойр тул Монгол, Оросын хооронд наймаа, арилжаа, соёлын холбоо эртнээс тогтсон газар билээ. Тиймээс эл бүс нутагт Монголын түүх, Монголчуудын амьдрал, түүх, соёлыг эртнээс сонирхон судалж ирсэн олон эрдэмтэн судлаачид аж төрж байсныг сэргээж, тэдний мартагдсан намтар, цадигийг нийтийн хүртээл болгосон гавьяатан бол Юрий Кузьмин билээ. Тэрбээр олон бүтээлээ нэрт судлаач А.В.Игумнов, Н.П.Шастина, И.К.Россохин, Н.Н.Козьмин зэрэг монгол судлаачдын намтар түүхийг тодруулж, тэдний монгол судлалд оруулсан хувь нэмрийг тодорхойлоход зориулжээ.

Цэргийн шинжлэх ухааны академийн сурвалжлагч гишүүн Ю.В.Кузьмин Орос-Хятад-Монгол гэсэн гурвал дахь монгол асуудал,

геополитикийн сэдвээрх XX зууны эхэн үеийн Оросын цэргийнхний бүтээлийг онцгойлон сонирхож байлаа. Энэ сэдвээр “XX зууны эхэн үеийн Монгол, Хятад Оросын цэргийн судлаачдын үнэлснээр” (Эрхүү, 2007), “XX зууны эхэн үеийн Монгол, Хятад Оросын цэргийн тагнуулын үнэлснээр” (Улаанбаатар, 2007) гэсэн нэг сэдэвт бүтээл, олон нийтлэл, илтгэл бичсэн байна. Ю.В.Кузьмин судалгаа шинжилгээний эрэл хайгуулынхаа дүнд Оросын цэргийн монгол судлаачид болох В.Л.Попов, А.М.Баранов, И.В.Тонких гэсэн цэргийн тагнуулч, хурандаа нарын тухай үнэтэй мэдээллийг шинжлэх ухааны эргэлтэд анх удаа оруулсан юм.

Профессор Ю.В.Кузьмин 2009 болон 2014 онд Халхын голын байлдааны түүхэнд зориулсан, олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, дотоод, гадаадын олон эрдэмтэн судлаачдыг оролцуулан, маргаан дагуулсан уг сэдвээр санал бодлоо уралдуулсан билээ. Тэрбээр Эрхүү хотноо Монгол судлалаар олон арван эрдэм шинжилгээний хурал болон Монголтой холбоотой олон арга хэмжээ санаачлан зохион байгуулсан нийгмийн идэвхтэй зүтгэлтэн төдийгүй Эрхүүгийн төр засгийнхан, Эрхүү дэх Монгол Улсын Ерөнхий консулын газар, монгол судлаач багш оюутан, бизнесмен, монгол оюутан сурагчдын дотнын зөвлөгч нь юм.

Ю.В.Кузьмин 1985 оноос Эрхүүгийн улсын их сургуулийн олон улсын факультетад, 2000 оноос өнөө хүртэл Эрхүүгийн Байгалийн улсын их сургуульд дэлхийн эдийн засгийн тэнхимийн профессор, 2023 оноос Эх орны түүхийн тэнхимд ажиллаж байна.

Тэр бээр Монгол болон Дорно дахин судлалаар 6 дэд эрдэмтэн төрүүлж, 40 гаруй магистрын удирдагчаар нь ажилласан байна.

Ю.В.Кузьминий эрдмийн бүтээлийг өндөр үнэлж, Буриадын улсын их сургуулийн гавьяат профессор (2013), МУИС-ийн хүндэт доктор, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн хүндэт доктор, Ю.Цэдэнбалын академийн академич (2007), ОХУ-ын Цэргийн шинжлэх ухааны академийн

сурвалжлагч гишүүн (2015), ОХУ-ын дээд мэргэжлийн боловсролын хүндэт ажилтан (2004) цолоор шагнасан байна.

Профессор Ю.В.Кузьмины мэндэлсний 60 насны ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар түүнд Монголын төрийн дээд шагнал - “Алтангадас” одон 2014 онд хүртээжээ. Кузьмин Ю.В. бол Монгол-Оросын харилцаа, Монгол-Тувагийн харилцаа, Монголын түүх судлал, Монголын түүхийн эх сурвалж судлалд үнэт хувь нэмэр оруулж буй нэрт монголч эрдэмтэн мөн болохыг Монгол Улсын эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрч, өндөр үнэлдэг юм. Тиймээс түүнийг Монгол Улсад Ю.Цэдэнбалын алтан од медаль (Монгол, 2007), “Алтан гадас” одон (Монгол, 2014), “Алтан од” одон (Монгол 2014), Орос-Монголын найрамдлын нийгэмлэгийн медаль (2008), “Соён гэгээрүүлэх үйлсийн төлөөх” медаль (2009), “Халх голын байлдааны ялалтын 80 жил” дурсгалын тэмдэг, “МАН-ы 100 жил” медаль (2021) зэрэг шагналаар шагнасан байдаг.

Тэр бээр сүүлчийн жилүүдэд Дэлхийн болон Оросын монгол судлалын талаар нарийн судалгаа хийж, уг сэдвээр олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны төсөл санаачлан хэрэгжүүлж, “XIX-XXI зууны Оросын Монгол судлаачид” (2021), “XX зууны Оросын монгол судлаачид: намтар өгүүлэл, бүтээлч өв, концепц” (2022), “XX зууны Монголын түүхчид” (2022), “Хилийн чанадын монгол судлал: үндэсний дэг сургуулиуд болон намтар өгүүлэл” (2023) гэсэн томоохон суурь бүтээлүүдийг орос хэлээр хэвлүүлжээ. Түүний эл бүтээлүүд нь Оросын монгол судлалд анх удаа Оросын болон дэлхийн монгол судлалын бүрэн зураглалыг танилцуулсан юм.

Эрхүү хотод Монгол судлал бий, Эрхүүд монголч эрдэмтэн Юрий Кузьмин амьдардаг, хэзээ ч хэн ч тэднийд буугаад мордоход монгол зангаар угтах монгол судлалын хөгжилд бүхнээ зориулсан бидний найз, монголчуудын нөхөр билээ. Эрхэм найздаа, нэрт монголч эрдэмтэн танаа 70 насны ойн баяр хүргэж, эрдэм судлалын өндөр амжилт хүсэж байна.

## Respected Colleague and Notable Scholar of Mongolian Studies - Yu.Kuzmin

**Batsaikhan Ookhnoi\***

Sc.D

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia  
batsaikhano@mas.ac.mn*

**Davaasuren Avirmed**

Sc.D

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia  
davaasurena@mas.ac.mn*

**Batbayar Tsedendamba**

Academician, Sc.D

*Institute of History and Ethnology, Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia  
tsedendamba.bud@gmail.com*

**Abstract:** *This commemoration honors Yuri Kuzmin, a distinguished Russian scholar of Mongolian studies, on the occasion of his 70th birthday. Kuzmin's extensive contributions encompass the history of Mongolia, Russian-Mongolian relations, and the development of Mongolian studies in Siberia. His academic journey began with a focus on Eastern history at Irkutsk State University, followed by a dissertation on Mongolian history, and has led to a prolific career with over 500 publications. Mongolian studies thrive in Irkutsk, where Yuri Kuzmin lives and works. As a devoted friend to the people of Mongolia, he has become a central figure in advancing Mongolian studies. Known for his warm hospitality, Kuzmin graciously welcomes all who visit, embodying the gracious spirit of Mongolian culture. Kuzmin's scholarship has significantly advanced the understanding of Mongolian history in Russia, Mongolia, and globally, making him a cherished friend and esteemed colleague within the field.*

**Keywords:** *Yuri Kuzmin, Mongolian studies, Russia-Mongolian relations*

<i>The day of submission:</i>	2024.08.22
<i>Completion of review:</i>	2024.10.23
<i>Final decision for acceptance:</i>	2024.11.08

---

\* Corresponding author